

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ
ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

2023 оны 08 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

№	Товч агуулга	Хэрэгжилт ирүүлэх байгууллагууд
1	Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл болон бусад асуудлуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлын сайтар хангаж, байгууллагын удирдлагууд НИТХ-ын дэд хороо, Намын бүлгийн хуралд идэвхтэй оролцох	✓ Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс
2	Нийслэлийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж, шаардлагатай бүх нөөцийг бүрдүүлэхэд анхаарч, хэрэгжилтийн явц, үр дүнг танилцуулах	✓ Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
3	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд эрүүл ахуй, чанар стандартын шаардлагад нийцсэн баталгаат хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, хүнсний аюулгүй байдалд хяналт шалгалт зохион байгуулж 10 дугаар сардаа багтаан дүнг танилцуулах	✓ Нийгмийн хөгжлийн хэлтэс ✓ Боловсролын хэлтэс
4	Нийслэлийн хэмжээнд байгаа хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг нийгэмшүүлэх, хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд рүү хандсан зөвлөмж, сургалтуудыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулж ажиллах	✓ Нийгмийн хөгжлийн хэлтэс ✓ Дүүргийн Цагдаагийн газар ✓ Гэр бүл, хүүхэд залуучуудын хэлтэс
5	Хөдөлгөөний ачаалал эрс нэмэгдэхтэй холбогдуулан авто замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээг бүрэн чөлөөлж, нийтийн тээвэр саадгүй зорчуулах, хөдөлгөөний зохицуулалт, аюулгүй байдал, зохион байгуулалтын ажлаа сайтар хангаж ажиллах	✓ Дүүргийн Цагдаагийн газар ✓ Замын цагдаагийн хэлтэс
6	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол гэмт хэрэг, зөрчлөөс иргэдээ урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлгөөн соёлтой оролцуулах чиглэлээр иргэд олон нийтэд болон нутгийн захиргааны байгууллагуудад уриалж, зөвлөмж чиглэлийг өгч ажиллах	✓ Дүүргийн Цагдаагийн газар ✓ Замын цагдаагийн хэлтэс
7	Хорооллын дундах болон туслах замын эвдрэл гэмтэл болон авто замын тэмдэг, тэмдэглэгээг засварлах ажлуудаа эрчимжүүлж, дуусгах	✓ Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс ✓ Замын цагдаагийн хэлтэс

№	Товч агуулга	Хэрэгжилт ирүүлэх байгууллагууд
8	Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн хяналтыг нэмэгдүүлэх, барилга угсралтын бүх шатанд стандарт, технологийн норм нормативыг мөрдлөг болгох, хяналтын инженерүүдийг газар дээр нь тогтмол ажиллуулж, хяналт тавьж ажиллах	<ul style="list-style-type: none"> ✓ Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс ✓ Санхүү, төрийн сангийн хэлтэс ✓ Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс ✓ Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс

2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 12:00 цагт багтааж, гарын үсэг, тамга тэмдэг дарж баталгаажуулан цаасаар болон файл / Мэргэжилтэн Бямбасүрэнгийн өг хаяг/-аар ирүүлнэ үү.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2023 оны 09 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

№	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл болон бусад асуудлуудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлын сайтар хангаж, байгууллагын удирдлагууд НИТХ-ын дэд хороо, Намын бүлгийн хуралд идэвхтэй оролцох				
1	“Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний төсөлд хэрэгжүүлэх боломжтой 7 төсөл, арга хэмжээний саналыг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 3/1450 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан.			70
Үүрэг даалгавар ХОЁР: Нийслэлийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж, шаардлагатай бүх нөөцийг бүрдүүлэхэд анхаарч, хэрэгжилтийн явц, үр дүнг танилцуулах				
2	Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2023 оны А/236 дугаар захирамжаар 45 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж 12 чиглэлд 118 заалт бүхий төлөвлөгөө боловсруулсан. Дүүргийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах ажил 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 94.5 хувьтай байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийн тайланг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд 1 удаа, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 7 хоног бүр тайлагнан ажиллаж байна. Дүүргийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, цаашид авах арга хэмжээний саналыг дүүргийн ИТХ-д 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар дахин танилцуулахаар бэлтгэл хангаж байна.			90
Үүрэг даалгавар ГУРАВ: Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд эрүүл ахуй, чанар стандартын шаардлагад нийцсэн баталгаат хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, хүнсний аюулгүй байдалд хяналт шалгалт зохион байгуулж 10 дугаар сард багтаан дүнг танилцуулах				

3	<p>2023-2024 оны хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хоол үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт шалгалт хийх ажлыг дүүргийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Боловсролын хэлтэс хамтарч Ерөнхий боловсролын сургууль 18, сургуулийн өмнөх боловсролын байгууллага 39 нийт 57 байгууллагыг хамруулан 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p>			30
<p>Үүрэг даалгавар ДӨРӨВ: Нийслэлийн хэмжээнд байгаа хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг нийгэмшүүлэх, хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд рүү хандсан зөвлөмж, сургалтуудыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулж ажиллах</p>				
1	<p>Дүүргийн цагдаагийн газрын хүүхдийн мэргэжилтэн нар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон зах худалдааны төвүүд, интернэт, цахим тоглоомын газар, авто угаалгын газар, дэн буудлын үйл ажиллагааг шалган, зөвлөмж мэдэгдэл хүргүүлж ажилласан.</p> <p>Цагдаагийн нэгдүгээр хэлтэс 2023 оны 03 дугаар улирлын байдлаар хүүхдийн эрх ашиг зөрчсөн, хүүхдэд тавих хараа хяналтаа сулруулсан, хүүхдээр гуйлга гуйлгуулсан, асран хамгаалах үүргээ үл биелүүлсэн 9 иргэнийг тус бүр 300 нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль ноогдуулсан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 23 иргэнийг дүүргийн Эрүүгийн хэргийн Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлж 7-20 хоногийн баривчилгаа болон албадан сургалтад хамруулсан, хараа хяналт сул, эрх ашиг нь зөрчигдсэн 5 хүүхдийг хороодын нийгмийн ажилтан, сургууль, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст холбон зуучилж ажилласан.</p> <p>Цагдаагийн хоёрдугаар хэлтэс "Хүүхэд хамгаалал-2023" нэгдсэн арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхэлдэг 8 хүүхдийг илрүүлэн оршин суух хорооны хамтарсан багт мэдэгдэн холбон зуучлан ажилласан.</p> <p>Мөн эрсдэлт нөхцөлд амьдардаг, 102, 108 тусгай дугаарт удаа дараагийн дуудлага мэдээлэл өгдөг өрхүүдээр дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн хүүхдийн эрхийн улсын байцаагч С.Одбаярын хамт сард 1 удаа очиж шалтгаан нөхцөлийг тодруулан, зөвлөгөө мэдээлэл өгч ажилдаг.</p>	Үүрэг даалгавар биелсэн	<p>-Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах -Дүүргийн хороодын болон Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтэстэй хамтран ажиллах - Илрүүлэх</p>	90

	Эрсдэлт нөхцөлд амьдардаг, хөдөлмөр эрхэлдэг хичээл завсардсан хүүхдүүдийг олж тогтоон оршин суудаг хорооны хамтарсан багт холбон зуучилж хичээл хоцрогдол арилгах тал дээр боловсролын хэлтэстэй холбогдон бүртгэл судалгаанд авч ажилсан.			
2	<p>2023-2024 оны хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах, түгжрэл саатлыг бууруулахад чиглэсэн “Хүүхэд хөдөлгөөний аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын 29 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 45 нийт 74 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, томоохон зах худалдааны төв “Алтжин”, “Юмт”, “Эрдэнэбулган”, “Нарантуул-2”, “Хүчит шонхор”, “Номин холдинг” –ХХК ийн удирдлагуудтай энэ оны 08 дугаар сарын 28-ны өдөр тус хэлтсийн удирдлага уулзалт зохион байгуулж ХАБ-ын ажилтан нэмэгдүүлэх, хүүхдийг зам тээврийн осол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хамтран ажиллах “Мэдэгдэл”-ийг хүргүүлэн ажилласан.</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллага, зах худалдааны төвийн гадна талбайд унадаг, дугуй, мопед, цахилгаан скутерын зогсоол талбайтай болгохоор дүүргийн боловсролын хэлтэст энэ оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 28л-3/444 дугаартай “Зөвлөмж”, томоохон зах худалдааны төвүүдэд мөн оны 08 дугаар сарын 21-ны өдөр 18-23 дугаартай мэдэгдлүүдийг хүргүүлсэн.</p>	Үүрэг даалгавар биелсэн	Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Ногоон гэрэл-цагаан шугам”, сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэгүүдийн дунд “Замын хөдөлгөөн-цагаан толгой” тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулах. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд эцэг эх, асран хамгаалагч нарын оролцоог нэмэгдүүлэх.	
Үүрэг даалгавар ТАВ: Хөдөлгөөний ачаалал эрс нэмэгдэхтэй холбогдуулан авто замын зорчих хэсгийн нэгдүгээр эгнээг бүрэн чөлөөлж, нийтийн тээвэр саадгүй зорчуулах, хөдөлгөөний зохицуулалт, аюулгүй байдал, зохион байгуулалтын ажлаа сайтар хангаж ажиллах				
1	<p>Нийслэл хотын гудамж замд байрлах чиглэлийн тээврийн хэрэгслийн зогсоолд хяналт тавьж иргэд олон нийтийг аюулгүй зорчих нөхцөл боломжоор хангах, зохиомол түгжрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор төлөвлөгөө гарган 7 хоног болгон хийсэн ажил, түүний нотломжийг Тээврийн цагдаагийн албанд танилцуулж, нийтийн тээврийн автобусны буудал дээр зогссон хувийн такси үйлчилгээнд явдаг иргэд жолоочид МУ-ын Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцон дахин зөрчил гаргахгүй байх талаар ухуулга сурталчилгаа хийж хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Мөн Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын 1, 2-р хэлтэстэй хамтран чиглэлийн тээврийн хэрэгслийн автобусны буудал дээр хяналт тавьж автомашинуудыг түр буюу удаан зогсоохгүй, нийтлэг үүргийн</p>	Үүрэг даалгавар биелсэн	Хөдөлгөөний ачаалал, түгжрэл саатлыг бууруулах зорилгоор Иргэд олон нийтийн дунд тээврийн хэрэгслээс татгалзаж нийтийн тээврийн хэрэгслээр зорчихыг уриалсан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж урамшуулах. Төрийн байгууллагын алба хаагчдыг ажилдаа очих,	90

	дагуу иргэд жолооч нартай зөв боловсон харилцаа үүсгэн Замын хөдөлгөөний дүрмийг баримтлахыг жолооч нарт сурталчлан ажиллаж байна.		тарах үед автобусаар хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх.	
Үүрэг даалгавар ЗУРГАА: Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол гэмт хэрэг, зөрчлөөс иргэдээ урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлгөөн соёлтой оролцуулах чиглэлээр иргэд олон нийтэд болон нутгийн захиргааны байгууллагуудад уриалж, зөвлөмж чиглэлийг өгч ажиллах				
1	<p>Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн баталсан "Хүүхэд-Хөдөлгөөний аюулгүй байдал" нөлөөлөл сурталчилгаа, хяналт шалгалт, хөдөлгөөн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран сайтад-1, FM-1, телевизэд-1, нийт 3 удаагийн сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд түгээн ажилласан.</p> <p>Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсээс Хүүхэд-Хөдөлгөөний аюулгүй байдал арга хэмжээний хүрээнд бэлтгэн гаргасан видео-5, шторк-8 нийт-13 мэдээ мэдээллийн тус цагдаагийн газрын page хуудсанд байршуулан алба хаагчдаар олон дагагчтай цахим группт шээр түгээлт хийлгэж иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл түгээн ажиллаж байна.Сургуулийн өмнөх боловсролын байгууллага 4, 70 дугаар цэцэрлэгүүдэд Хүүхдийг зам тээврийн осол хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Шар дарцаг", "Суудлын тохируулагч", "Шар хантааз" зэргийн тараан эцэг, эх асран хамгаалагч нарт өгч аюулгүй хүүхдийн тээвэрлэж явах талаар зөвлөмж өгч ажилласан.</p>	Үүрэг даалгавар биелсэн	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, телевиз, радио, сайт, FM зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын 1 өдрийн хөтөлбөрт Цагдаагийн байгууллагаас Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд сурталчлах, мэдээ мэдээлэл өгч байх талаар хамтран ажиллах.	90
Үүрэг даалгавар ДОЛОО: Хорооллын дундах болон туслах замын эвдрэл гэмтэл болон авто замын тэмдэг, тэмдэглэгээг засварлах ажлуудаа эрчимжүүлж, дуусгах				
7	<p>Тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Ерөнхий боловсролын 28 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 45 байгууллагын орчимд 2023 оны 08 дугаар сарын 25-наас 2023 оны 09 сарын 10-ны өдрийн хооронд зам замын байгууламжийн эвдрэл гэмтэл, тэмдэг тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж засварлах шаардлагатай сургууль орчмын бүс тэмдэг 8, явганы хүний гарцын тэмдэг 6, тэмдэглэл арилсан зөрлийг фото зургаар баримтжуулан холбогдох байгууллагад албан мэдэгдлээр хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын энэ оны А/265 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх орц гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрөл олгосон дүүргийн 1-9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт зам</p>	Үүрэг даалгавар биелсэн	Зам замын байгууламж, зорчих хэсгийн эвдрэл, гэмтэл хариуцсан байгууллагууд чиг үүргийн хүрээнд тавих хяналтыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх орц гарц	70

	<p>сэтэлсэн сүвлэсэн газруудыг газар дээр нь очиж үзэж нөхөн сэргээсэн эсэхэд шалгалт явуулах 2023 оны 05 дугаар сарын 03-наас 08 дугаар сарын 22-ны өдрийн нийт 19 байршилд дулааны шугам засварлах, цахилгааны шугам засварлах, зам сэтэлж сүвлэлээ хийх ажлууд бүрэн хийгдэж авто зам, ногоон байгууламжийн нөхөн сэргээлт хийгдсэн.</p>		<p>гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрлийн дагуу сэтэлгээ, сүвлэлээ, засвар үйлчилгээг ямар хугацаанд, хэрхэн нөхөн сэргээлт хийсэн талаар Замын цагдаагийн хэлтэст нотломжийн хамт хүргүүлж хамтран ажиллах.</p>	
<p>Үүрэг даалгавар НАЙМ: Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн хяналтыг нэмэгдүүлэх, барилга угсралтын бүх шатанд стандарт, технологийн норм нормативыг мөрдлөг болгох, хяналтын инженерүүдийг газар дээр нь тогтмол ажиллуулж, хяналт тавьж ажиллах</p>				
8	<p>Дүүрэгт Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас:</p> <ul style="list-style-type: none"> • Бэлтгэл ажил хийгдэж байгаа 4 төсөл арга хэмжээ: • Тендерийн шатандаа байгаа 7 төсөл арга хэмжээ: • Гэрээ байгуулах шатандаа байгаа 0 арга хэмжээ: • Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 23 төсөл арга хэмжээ: <p>Ажил 100 хувь дууссан 24 төсөл арга хэмжээ тус тус байна.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа авто зам, барилга байгууламжийн ажилд хяналт тавих ажлын хүрээнд нийт 26 гүйцэтгэгч компанид “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 7/1698 тоот албан бичгийг хүргүүлэн, хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний явцын дэлгэрэнгүй тайланг авч нэгтгэн удирдлагад танилцуулан ажилласан.</p> <p>“Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх” ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажилладаг Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Барилгын хөгжлийн төвөөс дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явцын талаар тайланг сар бүр авч нэгтгэн удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавин ажиллаж байна.</p>			90

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Д.БЯМБАСҮРЭН